



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/145

Булган сум

Сургалт зохион байгуулахад
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Насан туршийн боловсролын төвөөс “Алтаргана 2024” наадмын хүрээнд гар урлалын сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Насан туршийн боловсролын төвийн захирал (Т.Дэлгэрмаа)-д даалгасугай.

2.Гар урлалын сургалт зохион байгуулахад шаардагдах 942,000 (есөн зуун дөчин хоёр мянга) төгрөгийг “Шинэ багш” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

В.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны
03. дугаар сарын 06. -ны өдрийн А/145 дугаар
захирамжийн хавсралт

ГАР УРЛАЛЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Хэмжээ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Шатахуун	литр	2,520	373.8	942,000
	Нийт				942,000